



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/99

Улаанбаатар хот

Г Сургалт, дадлага зохион байгуулах тухай Г

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6, 13 дугаар зүйлийн 13.2, 30 дугаар зүйлийн 30.1.16, 30.2, 30.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн гэр хорооллын ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчид, цэцэрлэгийн хүүхдүүд, тэдний эцэг эхчүүдэд гал түймэр, осол гэмтэл, түлэгдэлтээс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох сургалт, дадлагыг 2019 оны 09 дүгээр сарын 23-27-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Сургалт, дадлагын удирдамжийг нэгдүгээр, шаардлагатай зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалт, дадлага зохион байгуулахад шаардагдах 5.315.000 (таван сая гурван зуун арван таван мянган) төгрөгийг зохих зардлаас гаргахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс (дэд хурандаа Д.Урантулга)-т зөвшөөрсүгэй.

4. Сургалт, дадлагын бэлтгэлийг хангаж, хугацаанд нь үр дүнтэй зохион байгуулахыг Багануур, Налайх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга нарт, сургалтын явцад хяналт тавьж ажиллахыг Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтэс (хурандаа Г.Нэргүй)-т тус тус үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга (дэд хурандаа Н.Нямхорлоо)-д даалгасугай.

ДАРГА,
ХУРАНДАА

Ж.ЧҮЛТЭМСҮРЭН



Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2019 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн
31/99 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



СУРГАЛТ, ДАДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг. Сургалт, дадлагын зорилго

Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчид, цэцэрлэгийн хүүхдүүд, тэдний эцэг эхчүүдэд болзошгүй гал түймэр, газар хөдлөлтийн аюул, гэр бүл, сургуулийн хүрээнд тохиолдож болох ахуйн осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх, аюул, осол тохиолдсон үед өөртөө болон бусдад тусламж хүсэх, үзүүлэх, хамгаалах мэдлэг олгоход оршино.

Хоёр. Сургалт, дадлага явуулах хугацаа, хамрах хүрээ

Сургалт дадлагыг 2019 оны 09 дүгээр сарын 23-наас 27-ны өдрүүдэд нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулиудын бага ангийн сурагчид, цэцэрлэгийн хүүхдүүд, тэдний эцэг эхчүүдэд зохион байгуулна. Үүнд:

д/д	Дүүрэг	Сургалтанд хамруулах хүний тоо			
		Эцэг эх	ЕБС-ийн сурагч	Цэцэрлэгийн хүүхэд	Нийт
1	Багануур	50	50	40	140
2	Багахангай	40	40	40	120
3	Баянзүрх	80	90	40	210
4	Баянгол	70	80	40	190
5	Налайх дүүрэг	50	50	40	140
6	Сонгинохайрхан дүүрэг	80	90	40	210
7	Сүхбаатар	80	80	40	200
8	Хан-Уул дүүрэг	80	80	40	200
9	Чингэлтэй дүүрэг	70	80	40	190
Нийт		600	640	360	1600

Гурав. Сургалт, дадлагыг зохион байгуулах байгууллага, бүрэлдэхүүн

Онцгой байдлын хэлтсийн Сургалт, урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах мэргэжилтэн нар дүүргийн Боловсролын хэлтэс, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэстэй хамтран сургалтыг зохион байгуулна.

Дөрөв. Сургалт, дадлагын чиглэл

Онолын хичээлээр болзошгүй гал түймэр, газар хөдлөлтийн тухай болон урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар мэдлэг олгож, түгшүүрийн дохиогоор барилга байгууламжаас гарах, аюулгүй зай талбайд байрших дадлага хийлгэнэ.

Дадлагын хүрээнд “Хэн ч Хэзээ ч Хаана ч Бэлэн” гамшгаас хамгаалах буухиа тэмцээнийг явуулж болно.

Тав. Тайлан мэдээ ирүүлэх

Сургалтын нэгдсэн илтгэх хуудсыг файлаар 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр nobg.surgalt@gmail.com хаягаар, баталгаажуулсан хувийг, сургалтанд хамрагдсан эцэг эх, сурагчдын нэрсийн жагсаалтыг хавсарган 10 дугаар сарын 01-ний өдөр Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтэст тус тус ирүүлнэ.

--oOo--